

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Есөнбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ГАА-2026/025/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Алтай хот

2026 он

Дарга, тэргүүлэх аудитор: Г.Гүнжидмаа

Утас: 99998431 Цахим хаяг: gunjidmaag@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Эрдэнэчимэг

Утас: 99175677 Цахим хаяг: erdenechimegd@audit.gov.mn

Ахлах аудитор: Э.Сүнжидмаа

Утас: 80048599 Цахим хаяг: sunjidmaae@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ГАА-2026/025/НА-СТА-ТШЗ



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

1402, Хөгжил хороолол, Жинст баг,
Есөнбулаг сум, Говь-Алтай аймаг, 82091
Утас: (976) 7048-4030,
Цахим шуудан: govialtai@audit.gov.mn

2026.08.12 № 52

танай _____-ны № _____-т

ЕСӨНБУЛАГ СУМЫН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА П.ЗОЛЖАРГАЛ
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Есөнбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй болно. Үүнд:

- Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, орон тоог иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлаагүй,
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын захирамжаар ажлын албаны албан хаагчдын үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл, тэтгэмж 200.0 мянган төгрөг, багийн хуралдаан даргалагч нарт урамшуулал 5,103.0 мянган төгрөг, хуралдааны үйл ажиллагааны зардал 14,500.0 мянган төгрөгийг зарцуулсан,
- Тайлант онд 8,208.6 мянган төгрөгийн компьютер бэлтгэхдээ цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй,

- Эрүүл хот чадавхжуулах ТББ -аас ирүүлсэн урилгын дагуу БНСУ-д дэлхийн хотын чуулга уулзалтад оролцоход 4,500.0 мянган төгрөгийг зарцуулсан,
- Албан томилолт олгох журмын дагуу томилолт хоолны мөнгө олгосон боловч, томилолтоор ажилласан албан хаагчдад хоолны мөнгийг давхардуулан 3 ажилтанд 700.0 мянган төгрөгийг олгосон,
- Өндөр насны тэтгэвэрт гарсан 1 албан хаагчийн тэтгэмжийг олгохдоо 342.2 мянган төгрөгийг дутуу тооцож олгосон,
- Санхүүгийн, гүйцэтгэлийн, нийцлийн аудитаар өгсөн нийт 21,003.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж, 2,413,911.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 албан шаардлага, 9,929.5 мянган төгрөгийн төлбөрийн актыг барагдуулаагүй байна.

Энэ нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 54 дүгээр зүйлийн 54.2, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 16 дугаар зүйлийн 16.5.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоол "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгож журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2 дахь заалтыг тус тус зөрчсөн, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар Алтайд үйлдвэрлэв, Цэвэр цэмцгэр-Алтай хот, Өсөлтийг өрх бүрд гэсэн 3 хөтөлбөрийг батлуулж, хэрэгжүүлэх ажлыг эхлүүлсэн байна. Шатрын сумын аварга шалгаруулах тэмцээнийг иргэдийн Төлөөлөгчийн Хурлын нэрэмжит болгон зохион байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд тус байгууллагын орон нутгаас санхүүжих төсвийг 452,226.1 мянган төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 5,353.1 мянган төгрөгийн санхүүжилтийг дутуу олгосон байна.

Бусад асуудал

Тайлант онд 6 зорилтын хүрээнд, 20 арга хэмжээ хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаснаас 18 арга хэмжээг бүрэн, 2 арга хэмжээг 50 хувьтай дутуу хэрэгжүүлж, нийт дүнгээр 90.0 хувиар үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.ГҮНЖИДМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>9,810,654.25</u>	<u>10,928,241.00</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
33	АВЛАГА	16,472,164.25	7,589,751.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	6,992,413.25	-
335	Бусад авлага	9,479,751.00	7,589,751.00
33510	Байгууллагаас авах авлага	1,890,000.00	-
33520	Хувь хүмүүсээс авах авлага	7,589,751.00	7,589,751.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3,338,490.00	3,338,490.00
354	Хангамжийн материал	3,338,490.00	3,338,490.00
35410	Бичиг хэргийн материал	453,000.00	453,000.00
35420	Аж ахуйн материал	2,555,490.00	2,555,490.00
35470	Бусад хангамжийн материал	330,000.00	330,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>33,749,428.56</u>	<u>32,496,762.10</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	33,749,428.56	32,496,762.10
392	Биет хөрөнгө	33,749,428.56	32,496,762.10
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	45,858,950.00	53,477,550.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(19,063,466.36)	(27,361,273.28)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	16,960,000.00	17,550,000.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(10,006,055.08)	(11,169,514.62)
393	Биет бус хөрөнгө	-	-
39301	Программ хангамж	285,000.00	285,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(285,000.00)	(285,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>53,560,082.81</u>	<u>43,425,003.10</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>53,560,082.81</u>	<u>43,425,003.10</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	53,560,082.81	43,425,003.10
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	4,613,124.40	4,613,124.40
51101	Өмч: - төрийн	4,613,124.40	4,613,124.40
512	Хуримтлагдсан үр дүн	48,946,958.41	38,811,878.70
51210	Өмнөх үеийн үр дүн	20,279,463.05	40,064,545.16
51220	Тайлант үеийн үр дүн	28,667,495.36	(1,252,666.46)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>53,560,082.81</u>	<u>43,425,003.10</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	339,490,000.00	446,873,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	339,490,000.00	446,873,000.00

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	339,490,000.00	446,873,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	310,822,504.64	448,125,666.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	310,822,504.64	448,125,666.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	286,534,900.81	291,960,967.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	159,776,688.17	194,665,451.46
210101	Үндсэн цалин	84,821,389.80	96,237,919.32
210102	Нэмэгдэл	41,691,271.98	50,091,195.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,687,226.39	17,655,448.35
210104	Урамшуулал	17,576,800.00	13,913,888.50
210105	Гэрээт ажлын хөлс	-	16,767,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	14,143,600.00	23,607,262.25
210201	Тэтгэврийн даатгал	10,623,600.00	15,826,629.03
210202	Тэтгэмжийн даатгал	880,000.00	1,961,833.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	440,000.00	980,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	440,000.00	980,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,760,000.00	3,857,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,076,990.00	5,499,700.00
210401	Бичиг хэрэг	5,350,940.00	1,183,600.00
210402	Тээвэр, шатахуун	4,356,000.00	3,550,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	370,050.00	766,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	2,410,000.00
210602	Тавилга	-	2,410,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,336,000.00	11,108,000.00
210701	Гадаад албан томилолт	-	4,500,000.00
210702	Дотоод албан томилолт	4,336,000.00	6,608,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	66,101,418.00	44,245,287.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	66,101,418.00	44,245,287.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,100,204.64	10,425,266.46
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,764,600.00	964,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,990,700.00	-
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,344,904.64	9,461,266.46
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,287,603.83	156,164,699.29
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	14,499,400.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	14,499,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,807,584.00	65,748,236.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	20,841,084.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	64,348,236.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,966,500.00	1,400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,480,019.83	75,917,063.29
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,480,019.83	75,917,063.29
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	28,667,495.36	(1,252,666.46)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	339,490,000.00	446,873,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	339,490,000.00	446,873,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	339,490,000.00	446,873,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	339,490,000.00	446,873,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	313,074,800.00	438,664,400.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	313,074,800.00	438,664,400.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	288,787,196.17	282,499,700.71
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	163,717,488.17	194,665,451.46
210101	Үндсэн цалин	88,762,189.80	96,237,919.32
210102	Нэмэгдэл	41,691,271.98	50,091,195.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	15,687,226.39	17,655,448.35
210104	Урамшуулал	17,576,800.00	13,913,888.50
210105	Гэрээт ажлын хөлс	-	16,767,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	17,000,000.00	23,607,262.25
210201	Тэтгэврийн даатгал	13,480,000.00	15,826,629.03
210202	Тэтгэмжийн даатгал	880,000.00	1,961,833.22
210203	ҮОМШӨ-ний даатгал	440,000.00	980,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	440,000.00	980,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,760,000.00	3,857,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,076,990.00	6,023,700.00
210401	Бичиг хэрэг	5,350,940.00	1,707,600.00
210402	Тээвэр, шатахуун	4,356,000.00	3,550,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	370,050.00	766,100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	2,410,000.00
210602	Тавилга	-	2,410,000.00
2107	Томилолт, зочны зардал	4,336,000.00	11,108,000.00
210701	Гадаад албан томилолт	-	4,500,000.00
210702	Дотоод албан томилолт	4,336,000.00	6,608,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	66,101,418.00	44,245,287.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	66,101,418.00	44,245,287.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	27,555,300.00	440,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	22,564,600.00	440,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,990,700.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	24,287,603.83	156,164,699.29
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	14,499,400.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	14,499,400.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	22,807,584.00	65,748,236.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	20,841,084.00	-
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	-	64,348,236.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,966,500.00	1,400,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	1,480,019.83	75,917,063.29
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,480,019.83	75,917,063.29
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>26,415,200.00</u>	<u>8,208,600.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	26,415,200.00	8,208,600.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	26,415,200.00	8,208,600.00
2200	Дотоод эх үүсвэрээр	26,415,200.00	8,208,600.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	26,415,200.00	8,208,600.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>(26,415,200.00)</u>	<u>(8,208,600.00)</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,613,124.40	20,034,348.05	24,647,472.45
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,613,124.40	20,189,463.05	24,802,587.45
C07	Тайлант үеийн үр дүн	-	28,667,495.36	28,667,495.36
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,613,124.40	48,856,958.41	53,470,082.81
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	4,613,124.40	48,856,958.41	53,470,082.81
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	(8,882,413.25)	(8,882,413.25)
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	4,613,124.40	39,974,545.16	44,587,669.56
D08	Тайлант үеийн үр дүн	-	(1,252,666.46)	(1,252,666.46)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	4,613,124.40	38,721,878.70	43,335,003.10

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	452,226,100.0	446,873,000.0	5,353,100.0	98.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	452,226,100.0	446,873,000.0	5,353,100.0	98.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	373,226,100.0	290,708,300.71	82,517,799.3	77.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	207,505,010.0	194,665,451.46	12,839,558.5	93.8
210101	Үндсэн цалин	106,179,000.0			

			96,237,919.32	9,941,080.7	90.6
210102	Нэмэгдэл	50,601,110.0			
			50,091,195.29	509,914.7	98.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	16,908,000.0			
			17,655,448.35	(747,448.4)	104.4
210104	Урамшуулал	28,713,900.0			
			13,913,888.50	14,800,011.5	48.4
210105	Гэрээт ажлын хөлс	5,103,000.0			
			16,767,000.00	(11,664,000.0)	328.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	23,675,200.0			
			23,607,262.25	67,937.8	99.7
210201	Тэтгэврийн даатгал	16,267,400.0			
			15,826,629.03	440,771.0	97.2
210202	Тэтгэмжийн даатгал	1,878,000.0			
			1,961,833.22	(83,833.2)	104.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,088,800.0			
			980,800.00	108,000.0	90.0
210204	Ажилгүйдлийн даатгал	683,800.0			
			980,800.00	(297,000.0)	143.4
210205	Эрүүл мэндийн даатгал	3,757,200.0			
			3,857,200.00	(100,000.0)	102.6
2104	Хангамж, бараа материалын зардал	5,285,490.0			
			6,023,700.00	(738,210.0)	113.9
210401	Бичиг хэрэг	2,248,000.0			
			1,707,600.00	540,400.0	75.9
210402	Тээвэр, шатахуун	3,037,490.0			
			3,550,000.00	(512,510.0)	116.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-			
			766,100.00	(766,100.0)	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,598,900.0			
			8,598,900.00	-	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,598,900.0			
			5,598,900.00	-	100.0
210602	Тавилга	3,000,000.0			
			3,000,000.00	-	100.0
2107	Томилолт, зочны зардал	11,500,000.0			
			11,108,000.00	392,000.0	96.59
210701	Гадаад албан томилолт	4,500,000.0			
			4,500,000.00	-	100.0
210702	Дотоод албан томилолт	7,000,000.0			
			6,608,000.00	392,000.0	94.4
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	112,161,500.0			
			46,264,987.00	65,896,513.0	41.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	112,161,500.0			
			46,264,987.00	65,896,513.0	41.2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,500,000.0			
			440,000.00	4,060,000.0	9.7
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,500,000.0			
			440,000.00	4,060,000.0	9.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,000,000.00			
			156,164,699.29	(77,164,699.3)	197.6
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-			
			14,499,400.00	(14,499,400.0)	
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-			
			14,499,400.00	(14,499,400.0)	
2132	Бусад урсгал шилжүүлэг	79,000,000.0			
			65,748,236.00	13,251,764.0	83.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн	77,000,000.0			
			64,348,236.00	12,651,764.0	83.5

	ТЭТГЭМЖ				
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.0	1,400,000.00	600,000.0	70.0
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	75,917,063.29	(75,917,063.3)	
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг		75,917,063.29	(75,917,063.3)	
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	452,226,100.0	446,873,000.00	5,353,100.0	98.8
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	452,226,100.0	446,873,000.00	5,353,100.0	98.8
132001	Орон нутгийн төсвөөс	452,226,100.0	446,873,000.00	5,353,100.0	98.8

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар 14,607.1 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын 3 алдаа¹-г аудитын явцад залруулж, баталгаажуулав.

Залруулсан алдаа:

- **Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой:** Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэргүйгээр 2,019.7 мянган төгрөгийг хөрөнгийг шилжүүлсэн,
- Үр дүнгийн тайланд бичиг хэргийн зардлыг 524.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг аудитын явцад залрууллаа.
- **Мэдээллийг орхигдуулсантай холбоотой:** Шилэн дансанд мэдээлэх төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 5 шийдвэрийн 12,064.0 мянган төгрөгийг мэдээллийг аудитын явцад нөхөн байршуулсан.

Залруулагдаагүй нийт 38,813.4 мянган төгрөгийн зөрчил нь тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс их байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 38,813.4 мянган төгрөгийн 7 зөрчил илэрснээс, 1,044.2 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт, 4,500.0 мянган төгрөгийн зөрчилд 1 сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага, 33,269.2 мянган төгрөгийн 4 зөвлөмж хүргүүллээ.

3.2 Төлбөрийн акт

1. Албан томилолт олгох журмын дагуу томилолт хоолны мөнгө олгосон боловч, томилолтоор ажилласан өдөрт унаа хоолны хөнгөлөлтийн мөнгийг давхардуулан 3 ажилтанд 700.0 мянган төгрөгийг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-т "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т "хуулиар зөвшөөрөөгүй бусад", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах;" Засгийн газрын 2019 оны 6 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам", Сангийн сайдын 2024 оны А/52 дугаартай "Дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн батлах тухай" тушаал," гэж заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Шийдвэрлэсэн нь: Төсвийн орлого болгох төлбөрийн акт тогтоосон.

2. Өндөр насны тэтгэвэрт гарсан 1 албан хаагчийн тэтгэмжийг олгохдоо 342.2 мянган төгрөгийг дутуу тооцож олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-т "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралт "Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгож журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1-д "Нэг удаагийн буцалтгүй тусламж тооцох үндсэн цалингийн хэмжээг тогтоохдоо тухайн албан тушаалын үндсэн цалингийн сүүлийн 3 жилийн дунджаар тооцно" заасантай нийцэхгүй, иж бүрэн байх, оршин байх, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Буцаан олгох төлбөрийн акт тогтоосон.

3.2 Албан шаардлага

1. Есөнбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өгсөн 2023 оны 01/104, 02/104, 03/104, 04/104, 05/104, 06/104 дугаар, 2024 оны 02/57 дугаар төлбөрийн акт, 2022 оны 02/105, 2023 оны 02/141, 2024 оны 02/100, 17/190 дугаар албан шаардлагыг хэрэгжүүлээгүй, заасан хугацаанд биелэлтийг ирүүлээгүй байна.
2. Эрүүл хот чадавхжуулах ТББ -аас ирүүлсэн урилгын дагуу Бүгд найрамдах Солонгос Улсад дэлхийн хотын чуулга уулзалтад оролцоход 4,500.000 (Дөрвөн сая таван зуу) мянган төгрөгийг үр ашиггүй, хэмнэлттэй зарцуулаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх"; Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13-т "албан тушаалын тодорхойлолтод заасан зорилго, зорилт, чиг үүргийн хэрэгжилтийг хангах", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалын хавсралтын 19 дүгээр зүйлийн 19.2-т "Шалгагдагч этгээд аудитын тайланг баталгаажуулсан тушаалд заасан хугацаанд багтаан албан шаардлага, төлбөрийн акт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлтийг Төрийн аудитын байгууллагад тайлагнана" Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах, 16 дугаар зүйлийн 16.5.4-т "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:Төрийн аудитын байгууллагаас өгсөн аудитын шийдвэрийг биелүүлээгүй, төсвийн үр ашиггүй зарцуулж албан үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн Есөнбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга П.Золжаргалд хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлсэн.

3.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Нэг. Хууль тогтоомжтой холбоотой

Илрүүлэлт: Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, орон тоог сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн тогтоолыг үндэслэж баталсан байна.

Энэ нь: Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-т “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны бүтэц, орон тоо, цалингийн санг Засгийн газраас тогтоосон хязгаарын хүрээнд Хурал өөрөө тогтооно” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Хууль тогтоомжийн дагуу Хурлын ажлын албаны бүтэц, орон тоог батлуулах.

Хоёр. Хууль тогтоомжтой холбоотой

Илрүүлэлт: Хурлын даргын захирамжаар ажлын албан хаагчдын үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл, тэтгэмж 200.0 мянган төгрөг, хуралдааны үйл ажиллагааны зардал 14,500.0 мянган төгрөг, багийн хуралдаан даргалагч нарт урамшуулал 5,103.0 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Энэ нь: Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1-т “Аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны зохион байгуулалтын асуудлаар Хурлын дарга захирамж гаргана”, 55 дугаар зүйлийн 55.1-т “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал төсөвтэй байх бөгөөд төсвийг Хурлын нарийн бичгийн дарга захиран зарцуулна” гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийг Хурлын нарийн бичгийн дарга эрх хэмжээнийхээ хүрээнд захиран зарцуулж байх.

Гурав. Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт

Илрүүлэлт: Тайлант онд 8,208.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Цахим дэлгүүрт байршсан бараа, үйлчилгээг бусад этгээдээс худалдан авахыг хориглоно” гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Цахим дэлгүүрт байршсан тоног төхөөрөмж, барааг бусад этгээдээс худалдан авахгүй байх.

Дөрөв. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой

Илрүүлэлт: Шаардах хуудас бичихдээ бөөн дүнгээр бичдэг, шатахууны талоныг орлого авахдаа тоо ширхгээр аваагүй, нярвын тайлан 3 нэр төрлийн зарлагаар зөрүүтэй, орлого аваагүй хөрөнгийг зарлагдсан, нягтлан бодогч нь нярвын тайланг хянадаггүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-т “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.6-т “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 20 дугаар зүйлийн 20.2.5-т “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”; гэсэн заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, тасалбар болголт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, түүнд тавих хяналтыг сайжруулж, үр дүнг тооцож ажиллах.

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг тайлан хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
								Залруулсан		Залруулаагүй			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	тоо	Дүн	тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Есөнбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Шилэн дансанд мэдээлэх төсөв, өмч, хөрөнгө зарцуулах 5 шийдвэрийн 12,064.0 мянган төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй	1	12,064.0	1	12,064.0	-	-	1	12,064.0	-	-	-	-
	Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын шийдвэргүйгээр 2,019.7 мянган төгрөгийг хөрөнгийг шилжүүлсэн	1	2,019.7	-	-	1	2,019.7	1	2,019.7	-	-	-	-
	Үр дүнгийн тайланд бичиг хэргийн зардлыг 524.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан	1	524.0	-	-	1	524.0	1	524.0	-	-	-	-
Дүн		3	14,607.7	1	12,064.0	2	2,453.7	3	14,607.7	-	-	-	-

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөгөөр)

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох а/ш	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
	Сумын Хурлын ажлын албаны бүтэц, орон тоог иргэдийн Хурлаар батлаагүй	1	-	-	-	-	-	1	-	-	-
	Хурлын даргын захирамжаар ажлын албан хаагчдын үр дүнгийн урамшуулал, ур чадварын нэмэгдэл, тэтгэмж 200.0 мянган төгрөг, хуралдааны үйл ажиллагааны зардал 14,500.0 мянган төгрөг, багийн хуралдаан даргалагч нарт урамшуулал 5,103.0 мянган төгрөгийн зарцуулалт хийсэн	1	19,803.0	-	-	-	-	1	19,803.0	-	-
	Цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй 8,208.6 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдаж авсан	1	8,208.6					1	8,208.3	-	-
Есөнбулаг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал	Шаардах хуудас бичихдээ бөөн дүнгээр бичдэг, шатахууны талоны орлогыг тоо ширхгээр аваагүй, нярвын тайлан 3 нэр төрлийн зарлагаар зөрүүтэй, орлого аваагүй хөрөнгийг зарлагдсан, нягтлан бодогч нь нярвын тайланг хянаагүй	1	5,257.6	-	-	-	-	1	5,257.6	-	-
	Өндөр насны тэтгэвэрт гарсан 1 албан хаагчийн тэтгэмжийг олгоходоо 342.2 мянган төгрөгийг дутуу тооцож олгосон	1	344.2	1	344.2	-	--	-	-	-	-
	Албан томилолт олгох журмын дагуу томилолт хоолны мөнгө олгосон боловч, томилолтоор ажилласан өдөрт унаа хоолны хөнгөлөлтийн мөнгийг давхардуулан 3 ажилтанд 700.0 мянган төгрөгийг олгосон	1	700.0	1	700.0					-	-
	Эрүүл хот чадавхжуулах ТББ -аас ирүүлсэн урилгын дагуу БНСУ-д дэлхийн хотын чуулга уулзалтад оролцоход 4,500.0 мянган төгрөгийг зарцуулсан	1	4,500.0							1	4,500.0

	Өмнөх аудитаар өгсөн санхүү, гүйцэтгэлийн болон нийцлийн нийт 3 заалт бүхий 21,003.0 мянган төгрөгийн зөвлөмж, 3 заалт бүхий 2,413,911.1 мянган төгрөгийн албан шаардлага, 9,929.5 мянган төгрөгийн төлбөрийн актын хэрэгжээгүй үлдэгдэлтэй /Хавсралт/	1	-	-	-	-	-	-	1	-
Нийт		8	38,813.4	2	1,044.2		4	33,268.2	2	4,500.0

Тав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТШЗ	1	1				1		
	НИЙТ	1	1				1		